



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 6 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 178

Улаанбаатар
хот

Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.16-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:


1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны саналын дагуу үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ болон “Эрдэнэ хүнс-САМО” ХХК-д тус тус 4 жилийн хугацаагаар олгосугай.

2. Паркийн үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журмыг батлан мөрдүүлж, зохих журмын дагуу дэмжлэг үзүүлэн хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн, Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт даалгасугай.

3. Паркийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор гадаадын хөнгөлөлттэй зээлд хамруулах асуудлыг судлан зохих журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн нарт даалгасугай.

4. Үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх орон нутгийн хөтөлбөр батлан хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга С.Батболд, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт, тус паркийн байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд эрхлэх асуудлынхаа хүрээнд зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр, Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Эрчим хүчний сайд П.Ганхүү нарт тус тус даалгасугай.

5. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан паркийн удирдлагуудтай гэрээ байгуулан ажиллаж, жил бүр дүгнэн Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

П.СЭРГЭЛЭН